



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/221

Мандалговь

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалт, Гамшгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт Бог малын мялзан өвчний голомт үүссэн Адаацаг, Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Луус, Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоосноос хойш 14 хоногийн хугацаанд өвчлөл дахиж бүртгэгдээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан ч малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Адаацаг, Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрцогт, Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Луус, Сайнцагаан сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.АНХБАЯР



4822100583